



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/3762 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/11637 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар Аюургинагийн Баясгаланг томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ